

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ОМА-2025/06-15-ШТА-ГА

ТӨЛӨВЛӨЛТӨӨС ШАЛТГААЛСАН АЛДАА, ЗӨРЧИЛ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.

Даланзадгад хот 2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn
Аудитор Э.Жамцдорж
Утас: 70533552 Цахим хаяг: jamtsdorje@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	2
Дүрслэлийн жагсаалт.....	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	3
БҮЛЭГ 1. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГААГААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖ БУУРЧ БАЙНА.....	5
A.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй байна.....	5
A.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.....	5
A.3 Батлагдсан зарим төсөл, арга хэмжээ нь өмчлөлд шилжихгүй зардлын шинжтэй, байгууллагын урсгал зардлын хэлбэртэй байна.....	7
БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.....	8
B.1 Худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.....	8
B.2 Тендерийн баримт бичгийг хуульд нийцүүлэн боловсруулж, батлуулсан байна.....	9
БҮЛЭГ 3. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА	10
B.1 Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд илэрсэн зөрчил хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна	10
B.2 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.....	15
ДҮГНЭЛТ.....	16
ЗӨВЛӨМЖ.....	17
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	18

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ШТА	Шууд тайлагнах аудит
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	2024 оны батлагдсан төсөв, ОНТХО-ын төлөвлөгөө	5
Хүснэгт 2	2024 оны шинэ, шилжих ТАХ-ны судалгаа	6
Хүснэгт 3	ТАХ-ы гүйцэтгэл	8
Хүснэгт 4	ХАА-нд мөрдөгдсөн журам	9

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх?
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх?
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх?

Аудитын хамарсан хүрээ

Аудитад түүврийн арга ашиглан Өмнөговь аймагт 2024 онд орон төсвийн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын аудитын стандарт MNS 6817-5:2020, гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,

- Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Э.Жамцдорж нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл:

Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2022 онд 439 төсөл, арга хэмжээнд 122,352.9 сая төгрөг, 2023 онд 770 төсөл, арга хэмжээнд 363,503.8 сая төгрөг, 2024 онд 818 төсөл, арга хэмжээнд 575,625.0 сая төгрөгийг тухайн онд санхүүжүүлэхээр батлагдсан байна. Эдийн засаг өсөхийн хэрээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байна.



Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагын хүн хүчний нөөц хязгаарлагдмал, нарийн мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй байгаа нь хөрөнгө оруулалтыг бүрэн хэмжээгээр шалгах боломжгүйд хүргэж, аудитын үр дүнг бууруулж байна.

БҮЛЭГ 1. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГААГААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖ БУУРЧ БАЙНА.

А.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй байна.

1.1 Аймгийн ИТХ-ын 2023 оны 12-р сарын 01-ний өдрийн 15/11 дүгээр тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хийх 152 төсөл, арга хэмжээнд 484,399.4 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

1.2 Төсөвт тодотгол хийж 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 19/28 дугаар тогтоолоор ерөнхий нэрээр 174 төсөл, арга хэмжээнд нэр төрлөөр задалбал 498 төсөл, арга хэмжээнд 435,683.9 сая төгрөг тухайн онд санхүүжүүлэхээр баталсан байна.

1.3 Төсөл, арга хэмжээг ерөнхий нэрээр баталснаас шалтгаалан зарим төсөл, арга хэмжээний санхүүжүүлэх дүнг хэтрүүлэх эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2¹-д заасантай нийцэхгүй байна. Иймд аймгийн Засаг даргад зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

1.4 Мөн 10 сумдын ИТХ тогтоолоор 2024 онд нийт 320 төсөл, арга хэмжээнд 139,231.6 сая төгрөг санхүүжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1 2024 оны батлагдсан төсөв, ОНТХО-ын төлөвлөгөө

№	Аймаг, Сумд	Нийт орлого	Нийт зарлага	ОНТХО-ын	
				ТАХ-ий тоо	Дүн /сая.төгрөг/
1	Баяндалай	3,882.7	3,882.7	3	40.0
2	Баян-Овоо	5,974.7	5,974.7	10	547.4
3	Булган	3,436.4	3,436.4	3	60.0
4	Гурвантэс	40,299.4	40,299.4	28	3,853.5
5	Даланзадгад	45,356.2	45,356.2	56	13,983.7
6	Мандал-Овоо	2,973.5	2,973.5	-	-
7	Манлай	5,392.3	5,392.3	6	228.6
8	Номгон	4,704.8	4,704.8	-	-
9	Ноён	4,772.7	4,772.7	3	60.0
10	Сэврэй	4,438.5	4,438.5	16	709.5
11	Ханбогд	396,995.5	396,995.5	118	108,657.2
12	Ханхонгор	3,906.4	3,906.4	-	-
13	Хүрмэн	3,573.4	3,573.4	-	-
14	Цогт-Овоо	3,747.1	3,747.1	-	-
15	Цогтцэций	74,355.7	74,355.7	77	11,801.2
16	Аймаг	2,091,928.2	2,091,928.2	498	435,683.9
	Нийт	2,695,737.5	2,695,737.5	818	575,625.0

Эх сурвалж: ИТХ-ын тогтоолууд

1.5 Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалт дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдуулж, эдийн засгийн ач холбогдлоор эрэмбэлсэн нь нотлогдохгүй. Мөн хөрөнгө оруулалтыг хэт жижиглэж төсвийн байгууллагуудын урсгал зардлын шинжтэй хөрөнгө оруулалт төлөвлөсөн байна.

А.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.

¹ Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

1.6 Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор нийт 818 төсөл арга хэмжээнд 574,915.5 сая төгрөг баталснаас шинээр хэрэгжүүлэх 601 төсөл арга хэмжээнд 356,893.0 сая төгрөг, өмнөх оноос шилжсэн 217 төсөл, арга хэмжээнд 218,022.5 сая төгрөг тус тус баталсан байна. (Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас)

Хүснэгт 2 2024 оны шинэ, шилжих ТАХ-ны судалгаа

№	Аймаг, сумдын нэр	2024 онд шилжих ТАХ		2024 онд шинэ ТАХ	
		ТАХ-ний тоо	Санхүүжих дүн /Сая төгрөг/	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн /Сая төгрөг/
1	Аймаг	141	165,853.1	357	269,830.8
2	Баяндалай			3	40.0
3	Баян-Овоо			10	547.4
4	Булган			3	60.0
5	Гурвантэс	17	2,749.7	11	1,103.8
6	Даланзадгад	13	1,312.7	43	12,671.0
7	Манлай			6	228.6
8	Ноён			3	60.0
9	Сэврэй			16	709.5
10	Ханбогд	27	45,481.1	91	63,176.1
11	Цогтцэций	19	2,625.9	58	9,175.3
	Дүн	217	218,022.5	601	356,893.0

Эх сурвалж: ИТХ-ын тогтоолууд

1.7 Сумдын ИТХ-р баталсан тогтоолууд харилцан адилгүй маягтаар бэлтгэсэн байна. Тухайлбал зарим тогтоол нь шинэ, шилжих төсөл, арга хэмжээг ангилагдаагүй төсөвт өртөггүй, эхлэх, дуусах хугацаагүй, эдийн засгийн ангилалгүй байна.

1.8 Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-т орон нутгийн төсвийг батлахдаа тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасныг тусгаж батлахаар заажээ. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад нэр, байршил хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг зааж, хавсралтаар батлахаар тусгасан.

1.9 Дээрх зөрчилд өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт өгсөн боловч 2024 оны сонгуулийн дүнгээс шалтгаалан зарим Засаг дарга нар өөрчлөгдсөн нь зөрчлийг давтан гарах шалтгаан болсон байна.

1.10 Төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу баталснаар иргэд, олон нийт бодитой, үнэн зөв мэдээллээр хангагдахгүй байх эрсдэлийг дагуулж байна. Иймд төсвийн тухай хуулийн 33.2.6-д заасан төсөл, арга хэмжээний мэдээллийг тусгаж байх албан шаардлагыг зарим сумдын Засаг дарга нарт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.11 Мөн Төсвийн тухай хуулийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагад олон нийтээр хэлэлцүүлсэн байх заалтыг аймаг, сумд хэрэгжүүлээгүй байна.

1.12 Иймд аймаг, сумдын Засаг дарга нарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

1.13 Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 793,850.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 147 барилга, байгууламжид хөрөнгийн ашиглалттай холбоотой

зардлын тооцоолол хийгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.2.4²-д заасантай нийцэхгүй байна.

1.14 Хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцоолол хийгээгүйгээс шалтгаалан ашиглагч байгууллагуудад төсвийн ачаалал үүсгэх, орон тооны хүрэлцээгүй байдал үүсэх зэрэг үр дагаврууд гарч байна. Иймд аймгийн Засаг даргад зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

1.15 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³-т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг боловсруулан батлуулдаг нийтлэг зөрчил давтагдсаар байна. (Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас)

1.16 Энэ нь төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг алдагдуулж, төсвийн төлөвлөлтийн зарчим хангагдахгүй байгааг харуулж байна.

А.3 Батлагдсан зарим төсөл, арга хэмжээ нь өмчлөлд шилжихгүй зардлын шинжтэй, байгууллагын урсгал зардлын хэлбэртэй байна.

1.17 Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁴-д заасантай нийцэхгүй орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авахад Даланзадгад сум 14 төсөл, арга хэмжээнд 2,239.7 сая төгрөг баталсан зөрчил илэрсэн. Иймд сумын Засаг даргад зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

1.18 Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-ын заалттай нийцэхгүй орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зардлын шинж чанартай 4,613.5 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг аймаг, сумд баталсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №1) Үүнд:

- Аймаг 12 төсөл, арга хэмжээнд 4,531.5 сая төгрөг,
- Манлай сум 1 төсөл арга хэмжээнд 82.0 сая төгрөг баталсан байна.

1.19 Дээрх зөрчилд аймаг, Манлай сумын Засаг дарга нарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

1.20 Аймгийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хувийн хэвшилтэй хамтран ажиллах, эргэн төлөгдөх нөхцөлтэй хүүгүй зээл олгосон байна. Үүнд:

- "Шохойн чулууны болон бусад барилгын материалын үйлдвэр байгуулах, зураг, төсөл, боловсруулах" 1,800.0 сая төгрөг,
- "Нутгийн үйлдвэрлэгч хөтөлбөрийг хэрэгжүүлж ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулах, ашиглалтад оруулах зорилгоор Ингэний сүүний кластерийн бодлогыг хэрэгжүүлж, сүү бэлтгэн нийлүүлэх түүхий эдийн сүлжээ бүрдүүлэх" 1,500.0 сая төгрөг,

² урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх

³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁴ "Төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

- "Өмнөговь аймгийн Даланзадгад суманд асфальтын үйлдвэр байгуулах" 4,039.2 сая төгрөгийн гэрээ тус тус байгуулсан байна.

1.21 Энэ нь Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5⁵, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2⁶, 6.3⁷-д заасантай нийцэхгүй байна.

1.22 Иймд дээрх байгуулсан гэрээг хувийн хэвшилтэй зөвшилцөн хуулийн хүрээнд өөрчлөлт оруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад өглөө.

1.23 Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 19/28 дугаар тогтоол дахь ОНТХ-аар 2024 онд хийгдэх 174 хөрөнгө оруулалт, их засвар, төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн "Нийт төсөвт өртөг"-ийн дүнг 1,050.0 сая төгрөгөөр зөрүүтэй батлуулсан зөрчилд алдааг давтан гаргахгүй байх албан шаардлагыг СТСХ-т хүргүүлээ.

1.24 Цаашид хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хуульд нийцүүлж төсөл, арга хэмжээний үр өгөөжийг нэмэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

Б.1. Худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжихээр баталсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг аймгийн Засаг дарга Худалдан авах ажиллагааны газар, сумдын Засаг дарга нарт олгосон байна.

2.2. ХАА-ны төлөвлөгөөнд төсөл, арга хэмжээний мөрдөх, журам, арга, тендер зарлах огноо хугацааг тодорхойлж хүргүүлсэн бөгөөд аймаг, сумдын Засаг даргын захирамжуудаар 389,484.0 сая төгрөгийн 511 төсөл, арга хэмжээнд ХАА-г зохион байгуулахаар байна.

Хүснэгт 3 ТАХ-ы гүйцэтгэл

№	Аймаг, сумд	ХАА-ны төлөвлөгөө		ХАА амжилттай		Тухайн ондоо амжаагүй, зарлаагүй	
		ТАХ	Төсөвт өртөг	ТАХ	Гэрээний үнийн дүн	ТАХ	Төсөвт өртөг
1	Аймаг	250	287,436.5	234	234,191.8	16	20,914.4
2	Баяндалай	2	30.0	2	30.0	-	-
3	Баян-Овоо	8	488.7	8	462.4	-	-
4	Булган	3	60.0	3	60.0	-	-
5	Гурвантэс	28	3,718.3	22	3,529.9	6	323.6
6	Даланзадгад	36	11,993.0	34	5,635.9	2	6,160.0
7	Манлай	10	293.2	10	289.6	-	-
8	Ноён	3	60.0	3	60.0	-	-
9	Сэврэй	16	709.4	16	688.4	-	-
10	Ханбогд	91	74,467.3	83	59,359.6	8	12,122.3
11	Цогтцэций	64	10,227.6	43	7,823.3	21	2,343.0
	Дүн	511	389,484.0	458	311,841.3	53	41,863.3

Эх сурвалж: Аудитын судалгаа

⁵ Орон нутгийн төсөвт Өрийн удирдлагын тухай хууль болон энэ хуулийн 41.5, 57.4, 62.2-т зааснаас бусад тохиолдолд өр үүсгэх, баталгаа гаргахыг хориглоно

⁶ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна

⁷ Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдтэй хамтарч хөрөнгө оруулсан бол төсвөөс санхүүжүүлсэн хувь хөрөнгийн хэмжээгээр төрийн болон орон нутгийн өмчид хамааруулна

2.3. ХАА-г зохион байгуулж 458 төсөл, арга хэмжээнд 311,841.3 сая төгрөгийн гэрээг байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаргуулсан байна.

2.4. Харин 41,863.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, хэрэгжиж дуусаагүй 53 төсөл, арга хэмжээ байна. Энэ нь ажлын тоо хэмжээ, ажлын даалгавар ирүүлээгүй, хөрөнгө татагдсан зэргээс шалтгаалсан байна.

Б.2 Тендерийн баримт бичгийг хуульд нийцүүлэн боловсруулж, батлуулсан байна.

2.5. Тендерийг зохион байгуулж гүйцэтгэгчийг шалгаруулахдаа нийт төсөл, арга хэмжээний 60 хувьд нээлттэй тендер шалгаруулалт, 21 хувьд харьцуулалтын арга, 1 хувьд ерөнхий гэрээний арга, 18 хувьд шууд худалдан авах аргыг ашигласан байна.

Хүснэгт 4 ХАА-нд мөрдөгдсөн журам

№	Аймаг, сумд	ХАА амжилттай		ХАА-нд мөрдөгдсөн журам			
		ТАХ-ний тоо	Гэрээний дүн	НТШ	ХА	ЕГ	ШХА
1	Аймаг	234	234,191.8	190	42	-	2
2	Баяндалай	2	30.0	-	-	-	2
3	Баян-Овоо	8	462.4	2	2	-	4
4	Булган	3	60.0	-	-	-	3
5	Гурвантэс	22	3,529.9	15	3	-	4
6	Даланзадгад	34	5,635.9	13	10	-	11
7	Манлай	10	289.6	-	4	-	6
8	Ноён	3	60.0	-	-	-	3
9	Сэврэй	16	688.4	1	4	-	11
10	Ханбогд	83	59,359.6	39	24	-	20
11	Цогтцэций	43	7,823.3	15	9	2	17
	Дүн	458	311,841.3	275	98	2	83

Эх сурвалж: Аудитын судалгаа

2.10 Худалдан авах ажиллагаанд тайлант онд сангийн яаманд тендерт оролцогчдоос 17 гомдол гарсан бөгөөд 17 тендер шалгаруулалтад нь захиалагчийн шийдвэрийг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн байна.

2.11 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁸-д цахим дэлгүүрээс худалдан авалт хийх буюу ерөнхий гэрээний аргыг ашиглах тухай заасан байдаг. Гэвч цахим дэлгүүрт байршсан зарим бараа, тоног төхөөрөмж нь зах зээлийн үнээс өндөр байдаг нь хөрөнгө оруулалтаар компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг тендер шалгаруулалтаар хэрэгжүүлэх шалтгаан болсон байна.

2.14 Төсөл, арга хэмжээг олон хувааж шууд гэрээ байгуулж хэрэгжүүлэх, мөн хэт байгууллагын урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

2.15 Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/1168 дугаар албан бичгээр Монгол Улсын сангийн яамны хууль, эрх зүйн газарт дараах төсөл арга хэмжээнүүдэд ХАА-г зохион байгуулах чиглэл авахаар хүргүүлсэн байна. Үүнд:

- "Шохойн чулууны болон бусад барилгын материалын үйлдвэр байгуулах, зураг, төсөл, боловсруулах" 1,800.0 сая төгрөг,

⁸ Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно

- "Нутгийн үйлдвэрлэгч хөтөлбөрийг хэрэгжүүлж ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулах, ашиглалтад оруулах зорилгоор Ингэний сүүний кластерийн бодлогыг хэрэгжүүлж, сүү бэлтгэн нийлүүлэх түүхий эдийн сүлжээ бүрдүүлэх" 1,500.0 сая төгрөг,
- "Өмнөговь аймгийн Даланзадгад суманд асфальтын үйлдвэр байгуулах" 4,039.2 сая төгрөг.

2.16 Сангийн яамны 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 03/4199 дүгээр албан бичгээр дээрх төсөл, арга хэмжээнүүдэд тендер шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулах чиглэл өгсөн байна.

2.17 Сумдын ЗДТГ-ын батлагдсан орон тоонд худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн байдаггүй нь зарим сумын худалдан авах ажиллагаанд зөрчил гарахад нөлөөлж байна.

2.18 Харин Цогтцэций сумын ЗДТГ-т шинээр худалдан авах ажиллагаа хариуцсан 2 мэргэжилтэн 2025 онд томилогдсон байна.

БҮЛЭГ 3. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ИЛЭРСЭН ЗӨРЧЛҮҮД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.

В.1 Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд илэрсэн зөрчил хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

3.1 Аймаг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 621,141.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 805 төсөл, арга хэмжээнд 2024 онд 575,625.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 793 ТАХ-нд 514,137.4 сая төгрөг олгосон нь нийт санхүүжих дүнгийн 89.3 хувийг нь эзэлж байна. (Дэлгэрэнгүйг аудитын нэгдсэн судалгаанаас)

3.2 Аудитын явцад төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй танилцахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ❖ Аймгийн төсвийн хөрөнгийн 52.3 сая төгрөгөөр зураг төсөл, 2,055.8 сая төгрөгөөр "Номын сангийн дотоод засал" гүйцэтгэсэн боловч зураг төсөлд заслын ажилд ашиглах материалын чанар үзүүлэлт, зарим эдлэхүүний хэмжээ, хийцлэлийг тодорхой тусгаагүй байна. Мөн ханын чимэглэл бат бэх муутай, түвшинтэй уншлагын суудал "Хүн-орчны зохицол"-ын шаардлага хангахгүй байна.

Зураг 1. Түвшинтэй уншлагын суудал



Зураг 2. Гоёлын хана цөмөрсөн байдал.



- ❖ Аймгийн төсвийн хөрөнгийн 2,677.2 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн Хүрмэн сумын уурын зуухны барилгын нүүрс татагч туузан дамжуулагчийн налуу огцом тул нүүрс налуугаар зөөгдөх үедээ буцаж унаж хаягдал гардаг, үнс буулгах, ачих хэсгийн талбайг стандартаас бага хэмжээтэй хийсэн нь шанагат машин багтах боломжгүй нь ажилчдад саад учруулж байна.

Зураг 3. Хүрмэн сумын уурын зуух



Зураг 4. Туузан дамжуулагчаас нүүрс унасан байдал



- ❖ "Шинэ мянган айл орон сууцны хөтөлбөрийн хүрээнд Номгон, Ноён сумдад 10 айлын орон сууц барих ажил"-ын гүйцэтгэл улирлаас шалтгаалсан түр зогсолт хийхдээ "хамгаалалтын горим"-ыг мөрдөж ажиллаагүй байна. Тухайлбал барилгын "Улаан шугам"-ыг барилгын ажлын талбайд тэмдэглэж. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүй, Төмөр бетон бүтээцийг хүчитгэлийн элементүүдийг хучиж бүрхээгүй нь орчны үйлчлэл, зэв тэсвэрлэлтийг ноцтой зөрчсөн нь бүтээцийн бат бэхийн үзүүлэлтийг хангахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Зураг 5. Ноён сумын 10 айлын орон сууц



Зураг 6. Номгон сумын 10 айлын орон сууц




- ❖ Даланзадгад сумын 5-р сургуулийн урлаг заалны барилгад 0.9 метрийн өндөр хашлагатай тайзны дээд түвшин дэх жигүүрийн "гэрэлтүүлгийн тавцан"-г төлөвлөсөн бөгөөд ашиглагч байгууллага хүүхдийн "харах тавцан"-ийн зориулалтаар ашиглаж байгаа нь унах эрсдэл үүсгэж байна. Мөн зарим цонх, хаалт, хашлага аюулгүй байдлын шаардлага хангахгүй байна.

Зураг 7. Арын жигүүрийн техникийн тавцан



Зураг 8. Магадлалын дүгнэлтээр орсон хашлага



- ❖ "Хүрмэн сумын ЭМТ-ийн барилга"-ын ашиглалтын явцад 1-р давхрын шалны доорх цэвэр усны шугамаас ус алдаж эвдрэлийг шуурхай засварлаагүй тул орцны хэсгийн шал, гонх, гадна довжоонд эвдрэл үүсэж ашиглалтын хугацааг богиносгосон байна.

Зураг 9. Барилгын үндсэн орцны хэсэг орчим



Зураг 10. Гадна хана, довжоо нэвчсэн байдал



- ❖ Гурвантэс, Цогтцэций сумдын нийтийн биеийн тамир, урлаг, соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах цэнгэлдэх"-ийн дээврийн поликарбонат хавтанг гүйцэтгэгчид хямд үнэтэй, чанарын үзүүлэлт хангахгүй хавтан ашигласны улмаас хагарал үүссэн байна.

Зураг 11. Гурвантэс сум



Зураг 12. Цогтцэций сум



- ❖ "Даланзадгад сумын 1-р сургуулийн биеийн тамирын заалны барилга"-ын зураг төсөлд гадна тохижилтын ажилд Авто зам ба зогсоол 179 мкв, ногоон байгууламж 32 мкв, шилмүүст мод 9 ширхэг суулгах ажлын санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон боловч тус гадна тохижилтын ажлуудыг гүйцэтгээгүй байна.
- ❖ Спорт заалны "агч модон шал"-ыг өөр өнгөөр угсарсан байхад улсын комисс хүлээж авсан байна

Зураг 13. Авто зогсоол төлөвлөсөн талбай



Зураг 14. Ногоон байгууламж төлөвлөсөн



Зураг 15. Заалны хананд үүссэн ан цав




Зураг 16. "Агч" модон шал



- ❖ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Түрээсийн орон сууц хөтөлбөр-ийг түрээслэх, өмчлөх хэлбэрээр хэрэгжүүлэх, хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд шилжин ирэх иргэдийг орон сууцаар хангах, түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх" 6,000.0 сая төгрөгийн ажилд газар эзэмшигчтэй хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулаагүй барилгын ажлыг эхлүүлсэн байна.
- ❖ Гурвантэс сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ӨГАГТСЗДТГ/202309044 Тендер шалгаруулалтын дугаартай "Таван багт шаардлагатай машин нийлүүлэх" ажлын худалдан авсан 7807 ӨМЕ улсын дугаартай SUZUKI JIMNY маркийн автомашин техникийн тодорхойлолтыг хангаагүй байна.
- ❖ Ханбогд сумын 2 дугаар сургууль, 29 дүгээр цэцэрлэгийн цогцолбор барилгын дотор засварын болон гадна заслын ажлын гүйцэтгэл зураг төсөл боловсруулаагүй, төсвийг бодитой тооцоолоогүйгээс хангалтгүй хийгдсэн байна.
- ❖ Сумын цэнгэлдэх хүрээлэнгийн их засвар, талбайн тохижилт, гадна зогсоолын ажлын гүйцэтгэл замыг ажлын зурагт тусгасны дагуу гүйцэтгээгүй байна.

- ❖ Нийтийн эзэмшлийн бие засах байгууламж барих ажлын дотор тохижилтыг ажлыг даалгаврын дагуу хийж гүйцэтгээгүй байна.
- ❖ Даланзадгад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 26-ний өдрийн 18/3 дугаар тогтоолоор баталсан "Зүүн сайхан 5 дугаар багийн цогцолбор тоглоомын талбайн ажлыг дуусгах" ажлын 80 хувийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлд хүрээгүй байхад олгосон байна.
- ❖ "Зүүн сайхан 5 дугаар багийн цогцолбор тоглоомын талбайн ажлыг дуусгах" ажлын гэрээг 2 удаа үндэслэлгүй сунгасан байна.
- ❖ Даланзадгад сумын 24 дүгээр цэцэрлэгт өргөтгөлийн барилгын хана, дам нурууны заагаар ноцтой ан цав үүссэн, багш ажилчдын ариун цэврийн өрөөний шугам хоолойнд эвдрэл гарсан, налуу шатыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгээгүй байхад комисс хүлээж авсан байна.

Зураг 17.Багана, дам нурууны хооронд үүссэн ан цав



- ❖ "Далан булгийн цэцэрлэгт хүрээлэнгийн Сургалт, мэдээллийн төвийн барилгын зураг төсөв (ТЭЗҮ) 2022 онд магадлалаар орсон ч шаардлага хангаагүй гэж дүгнэн ба дахин зураг төсөл хийлгэсэн бөгөөд магадлалын ингэхдээ магадлалын ерөнхий дүгнэлт хийлгээгүй, ажлын тоо хэмжээ өөрчлөгдсөн ч төсөвт өөрчлөлт ороогүй байна. Тус барилга нь эрчим хүч, цэвэр, бохир усны холболтын ажлыг гүйцэтгээгүй, цонх, хаалгыг чанаргүй суулгасан байхад улсын комисс хүлээж авсан байна.

Зураг 19. Цэвэр, бохирын хоолой



Зураг 20. Цонхны битүүмж



- ❖ Баян-Овоо сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд автомашин худалдан авах" ажлын техникийн тодорхойлолтод тусгасан моторын багтаамж 2.4-с дээш гэсэн шаардлагыг хангахгүй автомашин авсан байна.
- ❖ Цогтцэций сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 16/3 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн төвийн барилгын зоорины давхрын засвар хийх" ажлын гүйцэтгэлийг зоорины давхарт барилгын гадна хаших хийцээр их хэмжээний ус алдаж төсвийн хөрөнгө оруулалт үр дүнгүй болсон байна.

3.3 Дээрх илэрсэн зөрчлүүдэд дахин давтахгүй байх, арилгах албан шаардлага хүргүүлээ.

В.2 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад Төрийн аудитын байгууллагаас жил бүр аудит хийж байгаа ч алдаа зөрчил давтагдан гарсаар байна. Энэ нь төсөл, арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

3.5 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг ГХБХБГ болон "Өмнөговь корпорац" ОНӨААТҮГ, сумдын ЗДТГ-ын томилогдсон албан тушаалтнууд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

3.6 Сумдын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд мэргэжлийн бус сумын ЗДТГ-ын даргын томилсон албан тушаалтнууд хяналт хэрэгжүүлж байгаа нь хяналт хангалтгүй хэрэгжүүлэх үндсэн шалтгаан болж байна.

3.7 ГХБХБГ, "Өмнөговь корпорац" ОНӨААТҮГ-уудын тусгай мэргэжлийн орон тооны хүртээмжээс шалтгаалан зарим төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг хангалтгүй хийсэн байна.

3.8 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх ажлын тоо, санхүүжилт жил бүр өсөж байгаа тул захиалагчийн хяналтыг сайжруулж мэргэжилтнүүдийн чадвар, хүний нөөцөд анхаарах шаардлагатай байна.

3.9 Мөн аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 12 их засварт 30.0 сая төгрөгийн зохиогчийн хяналтын зардлыг төсөв зохиогчдод олгосон байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.32⁹-т заасантай нийцэхгүй байна.

3.10 Иймд дээрх зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

9 зураг төсөл зохиогчийн хяналт" гэж барилгын ажил, зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг зохиогчоос хянаж байгаа үйл ажиллагааг

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд аймаг, сумд нийт 818 төсөл, арга хэмжээнд 575,625.0 сая төгрөг баталсан байна.
- Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 19/28 дугаар тогтоол дахь ОНТХ-аар 2024 онд хийгдэх 174 хөрөнгө оруулалт, их засвар, төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн "Нийт төсөвт өртөг"-ийн дүнг 1,050.0 сая төгрөгөөр зөрүүтэй батлуулсан байна.
- Аймаг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 621,141.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 805 төсөл, арга хэмжээнд 2024 онд 575,625.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 793 ТАХ-нд 514,137.4 сая төгрөг олгосон байна.
- Төсөл, арга хэмжээг олон хувааж шууд гэрээ байгуулж хэрэгжүүлэх, мөн хэт байгууллагын урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Энхбат танаа:

➤ Хувийн хэвшилтэй хамтарсан "Шохойн чулууны болон бусад барилгын материалын үйлдвэр байгуулах, зураг, төсөл, боловсруулах", "Нутгийн үйлдвэрлэгч хөтөлбөрийг хэрэгжүүлж ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулах, ашиглалтад оруулах зорилгоор Ингэний сүүний кластерийн бодлогыг хэрэгжүүлж, сүү бэлтгэн нийлүүлэх түүхий эдийн сүлжээ бүрдүүлэх", "Өмнөговь аймгийн Даланзадгад суманд асфальтын үйлдвэр байгуулах" төсөл, арга хэмжээнүүд төсвөөс санхүүжүүлсэн хувь хөрөнгийн хэмжээгээр орон нутгийн өмчид бүртгэх.

Цогтцэций сумын Засаг дарга Д.Баттүвшин танаа:

➤ Эрүүл мэндийн төвийн барилгын зоорины давхарт их хэмжээний ус алдаж байгаад яаралтай арга хэмжээ авах.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/11

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар болон Өмнөговь аймгийн Засаг даргад хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг аудитор (Э.Жамцдорж)-т даалгасугай.

Ц.ӨСӨХБАЯР

Г-2 Бичиг хэргийн ТТГ 4625010039

